



ХАРИЛЦАН СУРЪЯ  
ХАМТДАА БҮТЭЭ

2022



Дижитал хувилбарт шилжинэ.

ISBN:



©Хүүхдийг Ивээх Сан 2022

Энэхүү сургалтын гарын авлага нь Хүүхдийн Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрийн өмч бөгөөд худалдаалах болон албан ёсны зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.

*Нэмж засварласан хоёр дахь хэвлэл.*

Номын дизайн: **Номун Ерөөл ХХК**

## ҮНДЭСЛЭЛ, АЧ ХОЛБОГДОЛ

Энтрепренершип мэдлэгийн талбар нэлээд өргөн агуулгатай хэдий ч хувь хүний ур чадварыг хөгжүүлэх энэхүү сургалт нь энтрепренершиппийг чадамж талаас нь тодорхойлж байна. Энтрепренершип гэдэг нь бусдад зориулан үнэт зүйл бий болгох замаар тодорхой хэрэгцээг шийдэх боломж болон санааг хэрэгжүүлэх чадамж юм (European Union, 2018).

Энэ үнэт зүйл нь нийгмийн, соёлын болон санхүү, бизнесийн шинж чанартай байж болдог. Яагаад энэ тодорхойлолтод үндэслэх болсон шалтгаан нь энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварын хүрээг хэрэгжүүлэх нь тийм ч амбицтай, хэцүү зүйл биш (боловсролын сургалтын орчинд сонгох хичээл, хөтөлбөр, насан туршдаа суралцахуй гэх мэт нь хэдийнээ танил болсон ойлголтууд) бөгөөд энэ сургалтын багш нар, хүүхэд залуучуудын хувь хүний ур чадвар (нийгэм сэтгэл хөдлөлийн), сэтгэлгээг хөгжүүлэх боломж олгодог.

Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалт нь

**Нийгэм сэтгэл хөдлөлийн суралцахуй,**

**21 дүгээр зууны ур чадвар,**

**Энтрепренершип боловсрол, болон**

**Нийгмийн инновацийн боловсрол**


гэсэн 4 үзэл баримтлалд үндэслэнэ. Сүүлийн жилүүдэд эдгээр үзэл баримтлалыг тус тусад нь гэхээс илүүтэй хүүхэд залуучууд сургуульдаа амжилттай суралцах, ажиллах, амьдрахад шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагыг хөгжүүлэхэд цогцоор нь судалдаг болсон байна. Тиймээс энэ цогц хөгжлийн хандлага энэхүү сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулгад шингэсэн болно.

Энэхүү сургалт нь энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх **МЭДЛЭГ, ЧАДВАР, СЭТГЭЛГЭЭ** гэсэн 3 үндсэн бүрэлдэхүүнтэй.

## ЭНТРЕПРЕНЕРШИПД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Сургалтад сургуулиас гадуурх хүүхэд залуучууд хамрагдах учраас тэднийг сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, сэдэл тэмүүллийг төрүүлэх нь сургалтын үйл ажиллагаа, арга зүйн гол шаардлага юм. Эдгээр хүүхэд залуучуудын хандлага, итгэл үнэмшил, сэтгэл хөдлөлд чиглэсэн хөгжүүлэх сургалтын үйл ажиллагааг энтрепренершипд тулгуурлан зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд сургалт нь суралцагчдын сонирхолыг төрүүлэх, тэдэнд өөртөө итгэх итгэл үнэмшлийг бий болгох зорилго бүхий бие даасан болон багийн үйл ажиллагаануудтай.

Хэрэв суралцагчдыг сэдэлжүүлж чадвал тэд бүтээлчээр сэтгэх, асуудлыг шийдэх, багаар ажиллах, шинэ ухагдахуун, стратеги, техникийг сурахад нээлттэй хандаж эхэлдэг.



## ЭНТРЕПРЕНЕРШИПД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

# Сургалтын зорилго

---

Энэхүү сургалт нь төслийн зорилтот сумдын 14-25 насны хүүхэд залуучуудад бие дааж ажил хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой юм.

Юуны өмнө сургалтад хамрагдсанаар суралцагчдад дараах сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- ✓ Ямар нэг зүйлийг бэрхшээлээс үл хамааран зогсолтгүй сайн хийх хүчийг олж авах эрмэлзэлтэй болох
- ✓ Өөрийн алдаанаас суралцах, түүнийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх
- ✓ Өөрийгөө бэрхшээлтэй асуудалд сорих, хүнд хэцүү цаг үед зогсолтгүй урагшлах, шантрахгүй байх
- ✓ Бусдын туршлагад сониучаар хандах, аливаа асуудалд нээлттэй байх, асуулт асуух
- ✓ Санаж бодсон зүйлээ үйл хэрэг болгох, аливаа бэрхшээлийг даван туулахдаа хамтаараа бууж өгөхгүй байх, сэдэл тэмүүлэлтэй хандах.
- ✓ Тодорхойгүй нөхцөл байдлыг зөв удирдан чиглүүлэх, эрсдэлийг бууруулах арга замыг тодорхойлох, хэрэгжүүлэх арга барил, дадлыг олж авна.

## **Мөн 21 дүгээр зууны ур чадварын хүрээнд:**

- ✓ Өөрийгөө таньж мэдэх, ухамсарлах, сэтгэл хөдлөлөө тодорхойлох, стрессийг удирдах, цагаа зөв зохицуулах, төлөвлөх, өөрийн давуу тал, хүчийг таньж мэдэх
- ✓ Бүтээлч, инновацийн ур чадвартай болох, шинэлэг боломжуудыг илрүүлэх, шинэ санаа гаргах, түүнийгээ турших
- ✓ Харилцааны янз бүрийн нөхцөл байдалд бусадтай зөв харьцах, ойлголцох, анхааралтай сонсох, асуулт асуух, өөрийн санаагаа тайлбарлах
- ✓ Багаар ажиллах
- ✓ Соёлын ялгаа, нийтлэг байдлыг таньж мэдэх, ухамсарлах

# ЭНТРЕПРЕНЕРШИПД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

- ✓ Шүүмжлэлт сэтгэлгээтэй байх, мэдээлэл цуглуулах, учир шалтгааныг эргэцүүлэх, ёс зүйтэй шийдвэр гаргах, өөрийн үйл хэргийг эргэж дүгнэх, бэрхшээлтэй тулгарах, түүнийг даван туулах чадваруудыг эзэмшинэ.

Дээрх сэтгэлгээ, чадварыг дараах мэдлэг, ойлголтоор дамжуулан хөгжүүлнэ. Үүнд:

- ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН СУУРЬ МЭДЛЭГ
- БИЗНЕС ТӨЛӨВЛӨЛТ
- САНХҮҮГИЙН МЭДЛЭГ
- НӨӨЦИЙГ ЗОХИСТОЙ ХУВААРИЛАХ, БОЛОВСРУУЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЭДЛЭГ
- ДИЖИТАЛ МЭДЛЭГ БОЛНО

# Хөтөлбөрийн суралцахуйн үндсэн үзэл баримтлал

ЭНЭХҮҮ ХӨТӨЛБӨР НЬ ЭНТРЕПРЕНЕРШИПД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТАД АШИГЛАХ ҮНДСЭН БАРИМТ БИЧИГ ЮМ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО НЬ ӨМНӨ ДУРДСАНЧЛАН СУРАЛЦАГЧДАД ТОДОРХОЙ МЭДЛЭГ, ЧАДВАР, СЭТГЭЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХЭД ОРШИНО. ЭДГЭЭР НЬ ЭНТРЕПРЕНЕРШИПИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗАЙЛШГҮЙ ШААРДАГДАХ УР ЧАДВАР УЧРААС СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ДААЛГАВАР, АЖИЛБАР НЬ ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ТОДОРХОЙЛОГДОХ ЮМ. ИЙМ УЧРААС ЭНЭ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН СУРАЛЦАХУЙН ОНОЛ НЬ ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН БОЛОВСРОЛЫН ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛТАЙ БАЙХ ХЭРЭГТЭЙ ЮМ.

Энтрепренерийн боловсролын талаар хийгдсэн судалгаагаар энэ нь уламжлалт сургалтаас нэлээд өөр юм. Учир нь энтрепренершипийн сургалт илүү шинэлэг, инновацлаг бөгөөд суралцагчдын үйл, идэвхтэй үйл ажиллагаанд суурилсан (Mwasalwiba, 2010), бодит асуудлыг шийдэхэд чиглэсэн байдаг. Энэ сургалт нь олон төрлийн хичээлийн мэдлэг, ур чадварын огтолцлолоор тодорхойлогддог, агуулгын хувьд нэлээд интеграцчилагдсан, суралцагчдын хамтын ажиллагаа, зөвшилцөл, шийдвэр гаргалтыг нэлээд их шаарддаг, төсөлт хэлбэрийн даалгавартай, сурах үйлийн явцад нэлээд ач холбогдолтой ханддаг юм (Lackeus, 2015).

Данийн эрдэмтэн, судлаач Иллерис **суралцахуйн 16 онолыг** судалсан бөгөөд тэр дундаас цөөн хэд нь энтрепренершипийн сургалтад хэрэглэх боломжтой гэж дүгнэсэн байдаг ба энэ дундаас хамгийн тохиромжтой нь экспансив суралцахуйн онол (Leont'ev, 1978; Engeström, 1987) гэж үзжээ.

Экспансив суралцахуйн онолын хөгжүүлэгчээр Финландын Хелсинкийн их сургуулийн эрдэмтэн Энгерстром зүй ёсоор тооцогддог. Түүний тодорхойлсноор суралцагчид ямар нэг үйлийн системийн үндсэн ухагдахууныг дахин тодорхойлох, тухайн үйлийн өмнөх хэлбэрээс илүү өргөн хүрээний боломжийг багтаах үйлийн

сэдэл бий болгох замаар хамтаараа хувирган өөрчлөх эсвэл өргөтгөх үйл явц юм (Engeström 2003, pp. 30-31). Энэ нь нийгмийн тодорхой хэсгийн соёл, итгэл үнэмшлийг шинэ соёл, үнэт зүйл болгон өөрчлөх эсвэл илүү өргөтгөн цоо шинээр бүтээх, тэднийг бусадтай олон янзын байдлаар хамтран суралцах боломжийг олгодог байна. Энэ нь илүү шинэлэг, инновацлаг, хүмүүсийн олон янзын туршлага, дадлаар тодорхойлогддог ба суралцагчдад хараахан **“бий болоогүй”**, урьдчилан мэдэх боломжгүй тэр нөхцөл байдалд ажиллаж, амьдрах ур чадварыг хөгжүүлдэг. Энэ утгаараа суралцагчдад эргэлзэх, асуулт асуух, нэгэнт тогтсон жишиг, нормд шүүмжлэлтэй хандах, илүү үр дүнтэй байдлаар өөрчлөх гэж оролдох, олон талт байдлаар асуудалд хандах, асуудлын учир шалтгаан, үр дагаврыг эргэцүүлэх, шинэ загвар, практикийг санал болгох, гэх мэт суралцахуйн **“хэвшмэл бус”** үйл, сэтгэлгээг дэмжиж өгдөг тодорхой цикл бүхий сурах үйл ажиллагаатай үзэл баримтлал юм.

## Экспансив суралцахуйн онолоор суралцахуй гэдэг нь:

1.

Ямар нэг зүйлийг танин мэдэхүйн арга хэрэгслээ ашиглан утга учиртайгаар бүтээдэг үйл явц

2.

Суралцагчийн харилцан яриа, оролцоо, хамтын ажиллагааны үр дүнд явагддаг үйл явц

3.

Одоо байгаа практикийн асуудлаа эргэж харж асуух, эргэлзэх, шүүмжлэлт байр сууринаас хандах замаар илүү шинэ санаа, зан үйлийг бүтээдэг үйл явц

гэж үздэг.

Энэ онолоор суралцахуй нь дараах 7 үйл ажиллагаагаар (Зураг) явагдах бөгөөд эдгээр нь суралцагчдад зүгээр нэг энтрепренершипийг бий болгохоос илүү түүнийг бий болгож хөгжүүлэхэд шаардагдах илүү шинэлэг, өргөн хүрээтэй мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжийг олгодог байна.





Эдгээр үйл ажиллагаа нь:

1. Эхлээд одоо байгаа практик эсвэл үзэл санааны талаар асуулт асуух, **шүүмжлэлтэй хандах**, магадгүй **хүлээн зөвшөөрөхгүй** байх замаар шинэ мэдлэг, чадвар, зан үйл бүтээх суралцахуйн хэрэгцээг тодорхойлох

---

2. Нөхцөл байдлын талаар **“яагаад”** гэж асуух, тайлбарлах замаар учир шалтгааны дүн шинжилгээ хийх. Энэ нь хоёр талтай үйл ажиллагаа юм. **Нэгдүгээрт** тухайн нөхцөл байдал өдий хүртэл яаж бий болсон буюу түүхэн хөгжил талаас нь харах, **хоёрдугаарт** тухайн нөхцөл байдлын өдөр тутмын практик болон түүнийг хэрэгжүүлэгч хүмүүсийн зохицуулалтад илэрч байгаа зөрчлийн талаарх эмпирик нотолгоо шинжилгээ хийх

---

3. Тухайн нөхцөл байдал дахь **практик үйлийн учир шалтгааныг илрүүлснээр** шинэ загвар, санаа боловсруулан дэвшүүлэх буюу нээлт хийх

---

4. Шинэ загвар, санаагаа **практикт туршиж сорих**, түүнийхээ хязгаарлагдмал байдал, боломж, үйл ажиллагааг **үнэлж дүгнэх** замаар сайжруулах

5. Шинэ загвар, санаагаа **практикт хэрэгжүүлж** илүү сайжруулах
6. Шинэ загвар, санааныхаа талаар, мөн **юу сурсан** талаараа эргэцүүлж, **цаашид юу сурах** шаардлагатайгаа тодорхойлох
7. Загвар, санаагаа эцэслэн боловсруулж, практикт **тууштай хэрэглэх**, бусдад санал болгох, **түгээн дэлгэрүүлэх**

Ийм учраас энтрепрнершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтын үйл ажиллагааг эдгээр 7 циклээр зохион байгуулж, удирдахаар төлөвлөөд байна.

Экспансив суралцахуйн үйл ажиллагааг суралцагчдын хамтын үйл ажиллагаа, зөвшилцөл, шийдвэр, эрэлхийлэлд тулгуурлан явуулах нь шинэлэг зүйлийг, зан үйлийг бүтээхэд чухал үр дүнтэй. Судлаачдын үзэж байгаагаар<sup>2</sup> суралцагчид хамтаараа аливаа төслийг гүйцэтгэх явцдаа суралцдаг арга зүй нь энтрепрнершип сургалтад хамгийн тохиромжтой бөгөөд суралцагчид өөрийн сурах үйлээ өөрөө удирдан суралцах нь энэ арга зүйн хамгийн цөм зарчим юм.

Энтрепрнершип сургалтад багшийн үүрэг хамгийн чухал байдаг учраас багш өөрөө шинийг санаачлагч, бүтээгч, энтрепрнер сэтгэлгээтэй, асуудлыг шийдэх, хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай, оновчтой ашигладаг энтрепрнерүүд байх нь энэ сургалт амжилттай байх үндэс юм (European Commission, 2014; Heinonen & Poikkijoki, 2006; Peltonen, 2015).



2 Komarkova, Gagliardi, Conrads, and Collado (2015)



## Сургалтын арга зүй

Экспансив суралцахуйд суралцагчид практикийн асуудалд шүүмжлэлт байр сууринаас хандаж, түүнийг сайжруулах, хөгжүүлэх шинэ санаа боловсруулах, түүнийгээ турших, боломжийг тодорхойлоход хамтаараа хүчин чармайлт гаргадаг учраас энэ суралцахуйг удирдан чиглүүлэх, хөтлөхөд төсөлд суурилсан арга зүй хамгийн тохиромжтой.

**Төсөлд суурилсан арга зүй** нь динамик шинж чанартай, уян хатан байдаг. Бие даасан ажил, багийн үйл ажиллагаанд нэлээдгүй хугацааг зарцуулах бөгөөд үүний үр дүнд тодорхой бүтээгдэхүүн, илтгэл, үзүүлэн, гүйцэтгэл гарч байдгаараа бусад сургалтаас давуу талтай. Сургалтын үйл ажиллагааны явцад тодорхой хугацаанд төслийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад үнэлгээ тогтмол хийж ахиц дэвшлийг харах, ажиглах, түгээх боломжтой байдаг. Төсөлд суурилсан сургалтын бас нэг онцлог нь бодит амьдрал, орчны асуудлыг шийдэх боломжит шийдлүүдийг хайдагт орших бөгөөд энэ нь суралцагчдын сонирхол, сэдэл тэмүүллийг төрүүлж чаддаг.

Төсөлд суурилсан сургалтын хамгийн чухал шинж чанар бол суралцах үйл ажиллагааны цар хүрээ нэлээд гүнзгий, тэдний идэвхтэй оролцоог шаарддаг, хамтын шийдэлд үндэслэн ажлыг илүү чанартай хийх, сурах боломжийг олгодог явдал юм. Эдгээр элементүүд нь:

- ✓ **Бэрхшээлтэй асуудал, асуултуудыг тодорхойлох**
- ✓ **Асуудлын шийдэл, асуултын хариултыг тасралтгүй эрэлхийлэх**
- ✓ **Бодит орчин, бодит амьдралд суурилах**
- ✓ **Сургалтаар эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэлгээг хэрэглэх**
- ✓ **Судлагдахууны интеграцийг хангах**
- ✓ **Суралцагчдын дуу хоолой, сонголтууд нээлттэй байх**
- ✓ **Орон нутгийн бодит иргэдэд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгохыг зорих**
- ✓ **Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар шүүмж сонсож, эргэцүүлэх, улмаар түүнийг сайжруулах явцын болон төгсгөлийн үнэлгээ юм.**

# ЭНТРЕПРЕНЕРШИПД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Төсөлд суурилсан арга зүйгээр сургалтыг удирдан чиглүүлэхэд ямар төсөл сонгох вэ гэдэг чухал асуудал байдаг. Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрт төслийн удирдамжийг урьдчилан боловсруулсан тул төдийлөн бэрхшээл гарахгүй.



Төсөлд суурилсан сургалтад багийн гишүүдийн тоо их чухал. Ихэнх төслийн хувьд **нэг баг 4 суралцагчаас бүрдэх** нь чиг үүргээ шударга, тэнцвэртэй хуваарилах, өөрийн хувь хүний ур чадвараа бусдад дулдуйдалгүйгээр хөгжүүлэх боломжийг олгодог.<sup>3</sup> Баг бүрдүүлэх хэд хэдэн техникийг ашиглаж болох ба эдгээрийн тухай Багшийн гарын авлагаас үзнэ үү?



## Баталгаажуулалт, цаашдын дэмжлэг

Сургалтад хамрагдаж, шаардлагатай мэдлэг, чадвар эзэмшсэн суралцагчид гэрчилгээ олгоно. Түүнчлэн сургалтын явцад эзэмшсэн мэдлэг чадвараа хэрэглэн төслийн санал боловсруулж хэрэгжүүлэх боломжтой.

<sup>3</sup> Buck Institute for Education. Project based learning: Forming teams



## Багшид үзүүлэх дэмжлэг

Энэхүү сургалтыг зохион байгуулахад багшид дараах дэмжлэг үзүүлж, нөөц хэрэглэгдэхүүнээр хангаж ажиллана. Үүнд:

### СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

- Хөтөлбөр
- Багшийн гарын авлага
- Суралцагчийн гарын авлага
- Нөөц материал болон бусад хэрэглэгдэхүүн

### ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛ

- Сургууль, багш, суралцагчидтай хамтран ажиллах төлөвлөлт
- Орон нутгийн нийгмийн асуудлыг шийдэх бизнес санааг турших, амьдралд хэрэгжүүлэхэд нь дэмжих

## ДЭМЖЛЭГ



### ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТ

- Танхимын болон онлайн сургалт
- Ажлын байран дахь менторын дадлагажуулалт
- Онлайн зөвлөгөө, мэдээлэл

### БУСАД ДЭМЖЛЭГ

Сургалтын явцад төслийн зөвлөх, ментор, хамт олон болон орон нутгийн дадлага туршлагатай жижиг, дунд бизнес эрхлэгчид болон нийгмийн энтрепренертэй санал бодлоо хуваалцаж, туршлага солилцох боломжтой

## Сургалтын зохион байгуулалт

Сургалтын хөтөлбөрийг суралцагчийн нас, хөгжлийн онцлогт үндэслэн **3 бүлгээр** хэрэгжүүлнэ. Үүнд:

**БҮЛЭГ 1.** СУРГУУЛИЙН **8-12** ДУГААР АНГИЙН СУРАЛЦАГЧДЫН БҮЛЭГ

**БҮЛЭГ 2.** СУРГУУЛИАС ГАДУУРХ **14-18** НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН БҮЛЭГ

**БҮЛЭГ 3.** **19-25** НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН БҮЛЭГ

Бүх суралцагчид суралцахуйн зорилт дахь мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшинэ гэхдээ бүлгүүд ялгаатай даалгавар, төслийг гүйцэтгэнэ.

Сургалт үргэлжлэх нэгж хугацааг **40 минутаар** тооцно. **Танхимын сургалт** нийтдээ **1720 минут** буюу **43 цаг**, танхимын бус сургалт (бие даасан, төсөлт ажил) **920 минут** буюу **23 цагаар** тус тус зохион байгуулна. **Танхимын бус сургалтын** хугацааг багш болон зөвлөхийн суралцагчдад өгөх зөвлөгөө, саналд зарцуулагдах хугацаагаар тооцсон бөгөөд суралцагчд 24 цагаар хязгаарлагдалгүйгээр суралцах юм.

## Сургалтын цагийн хуваарилалт

Бүлэг	Зохион байгуулалтын хэлбэр	ДОЛОО ХОНОГ										НИЙТ ЦАГ
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	
Бүлэг 1	Танхимын	4	2	5	2	5	5	6	5	5	4	43
	Танхимын бус	2	4	2	4	2	2	0	2	2	3	23
Бүлэг 2	Танхимын	7	8	9	10	9						43
	Танхимын бус	6	6	4	2	5						23
Бүлэг 3	Танхимын	7	8	9	10	9						43
	Танхимын бус	6	6	4	2	5						23



Танхимын  
сургалтын үйл  
ажиллагаа



Танхимын бус  
сургалтын үйл  
ажиллагаа

Суралцагчид бие даан болон багаар ажиллах анги танхим, ширээ сандлын зохион байгуулалтыг оновчтой төлөвлөнө. Сургалтыг зөвхөн танхимд зохион байгуулахаас гадна танхимын бус орчинд явуулна. Тиймээс танхимаас гадуурх үйл ажиллагааг гүйцэтгэх анги танхим, нөхцлөөр хангах шаардлагатай.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах хүмүүстэй хамтын ажиллагаатай байж, сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулахад анхаарах хэрэгтэй. Үүнд:

- **Өөрийн аж ахуйг байгуулж, ажиллуулж байгаа хүмүүс**
- **Аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлж буй хүмүүс жишээ нь: санхүүч, орон нутгийн бизнесийн байгууллага, төрийн байгууллагууд**
- **Энтрепренершип ур чадварыг эзэмшсэн хүмүүс. Жишээлбэл: асуудлыг боломж болгосон шинийг санаачлагч, зохион бүтээгч, маркетингийн мэргэжилтнүүд зэрэг болно.**

### Танхимын бус сургалтын үйл ажиллагааны тухай

Сургалтын явцад багш, зөвлөхүүд хамтран ажиллах бөгөөд танхимын болон танхимын бус үйл ажиллагааг ч мөн хамтаараа зохион байгуулна. Танхимын бус сургалтын үйл ажиллагааг явуулахаас өмнө багшийн өгсөн даалгавар, төслийг суралцагчид багаараа гүйцэтгэх бөгөөд урьдчилан багийн ажлын төлөвлөлт хийх, ажлаа хуваарилах, танхимаас гадуур ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх зэрэгт багш, зөвлөхүүд суралцагчдад тусална. Мөн төсөл, даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ. Ялангуяа сургалтаас гадуурх багийн ажил, төсөлт ажлыг гүйцэтгэхэд эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэлгээг бодит нөхцөлд буулгах, хэрэглэхэд түлхүү анхаарах хэрэгтэй.

Танхимаас гадуур гүйцэтгэх ажлын удирдамжийг суралцагчийн дасгал ажлын номонд дэлгэрэнгүй үзүүлсэн байгаа тул багш, зөвлөхүүд түүнтэй урьдчилан танилцсан байх шаардлагатай.



# 1. ЗОРИЛТ



**Энэхүү сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлнэ.**

**Үүнд:**

**А. Сэтгэлгээ:** Сургалтын явцад суралцагчид өсөлтийн болон энтрепренер сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой.

#### **Өсөлтийн сэтгэлгээ**

Энэхүү сургалтаар суралцагчдын эзэмших (1) ур чадвар нь төрөлхийн биш байх бөгөөд харин шаргуу хөдөлмөр, практикийн үр дүнд хөгждөг, (2) алдаа гаргах нь ухаантай бусын шинж биш харин түүнийгээ хүлээн зөвшөөрч дараа дараагийн үйл ажиллагаандаа давтахгүй байх. Хүүхэд залуучууд аливаа асуудлыг хүнд хэцүү, бэрхшээлтэй байсан ч тасралтгүй оролдлого, шаргуу чанараар шийдэж, амжилтад хүргэдэг гэдгийг төлөвшүүлэхийг хичээнэ. Алдах нь асуудал биш харин түүнийг хүлээн зөвшөөрч дараа дараагийн үйл ажиллагаанд давтахгүй байх нь хувь хүн хөгжихөд чухал чанар гэдгийг ойлгох болно. Өөрийн хүсэл мөрөөдөл, зорилгодоо хүрэхэд өөрийгөө сорих, бууж өгөхгүй байх хэрэгтэй гэдэг сэтгэлгээтэй болох юм.

#### **Энтрепренершип сэтгэлгээ**

Суралцагчид (1) санаачилгатай байх, саад бэрхшээл тулгарсан ч зорилгодоо хүрэхийн тулд идэвхтэй байх (2) амжилтандаа сэтгэл хангалуун байсан ч, жижиг бизнес эрхэлж байсан ч, ажил хайж байсан ч үргэлж сониуч байж эрсдэлийг тооцоолдог, удирддаг, санаагаа туршиж үздэг байхыг хэлнэ.




Хүүхэд залуучуудад шинэ санаа боловсруулах, туршлага хуримтлуулахад туслах ба асуудалд нээлттэй хандах, үргэлж асууж, эрэлхийлдэг байхад сургадаг. Түүнчлэн санаагаа хэрхэн үйл хэрэг болгох, хүмүүстэй хамт баг байгуулж, хамтран ажиллах, үргэлж санаачилгатай, эрмэлзэлтэй байхад тусална. Мөн тэд өөрсдийн ашиг сонирхлоо жолоодох, тодорхойгүй нөхцөл байдлыг даван туулах, удирдах, эрсдэлээ хянаж сурна.

**В. Чадвар:** Суралцагчдын өөрийгөө танин мэдэх, боломжийг олж харах, бүтээлч, шинэ санаа гаргаж, турших, янз бүрийн нөхцөлд, зохих арга техникийг ашиглан үр дүнтэй харилцах, багаар ажиллах, нийгэм, соёлын үзэгдэлд хүндэтгэлтэй хандах, тунгаан бодох- мэдээлэл цуглуулах, учир шалтгааныг тодруулах, ёс зүйтэй шийдвэр гаргах, эргэцүүлэн бодох, дасан зохицох чадваруудыг хөгжүүлнэ.

ЧАДВАР	БҮРЭЛДЭХҮҮН ЧАДВАР
<p><b>1.</b> ӨӨРИЙГӨӨ ОЙЛГОХ ТАНИН МЭДЭХ</p>	<p>1.1 Өөртөө итгэх итгэл 1.2 Сэтгэл хөдлөлөө ойлгох, тодорхойлох 1.3 Сэтгэл хөдлөлөө удирдах 1.4 Стрессээ удирдах 1.5 Өөрийгөө бодитоор үнэлж дүгнэх /Сул болон давуу талаа мэдэх/</p>
<p><b>2.</b> НИЙГЭМ СОЁЛЫН ОРЧЛЫГ ТАНИН МЭДЭХ</p>	<p>2.1 Бусдын байр сууринд өөрийгөө тавьж үзэх 2.2 Ялгаатай байдал үзэл бодлыг ойлгон хүндэтгэлтэй хандах 2.3 Бусдыг хүндлэн ёс зүйтэй үйлдэл хийдэг байх / Бусад суралцагчдын нийгмийн байдал өмссөн зүүсэн, эд хэрэглэлийн талаар зохисгүй үг хэллэг хэрэглэхгүй байх гэм мэт/ 2.4 Аливаа зүйлийг олон талын өнцгөөс харах 2.5 Үр дагаврыг тооцоолон ёс зүйтэй шийдвэр гаргах</p>
<p><b>3.</b> БҮТЭЭЛЧ БАЙДАЛ, ИННОВАЦИ</p>	<p>3.1 Боломжийг илрүүлэх, 3.2 Шинэ санаа эрэлхийлэх, олох 3.3 Илрүүлсэн боломжоо үнэлж дүгнэх, төсөөлөх 3.4 Алсын хараагаа тодорхойлох 3.5 Гаргасан санаагаа турших</p>

<p>4. <b>ХАРИЛЦАХ</b></p>	<p>4.1 Бусдыг анхааралтай сонсох 4.2 Асуулт асуух 4.3 Хариултыг ойлгох /Хариултыг бүрэн гүйцэт сонсох/ 4.4 Өөрийн санаа бодлоо бусдад ойлгомжтой , тодорхой илэрхийлэх 4.5 Аман болон аман бусаар санаа бодлоо илэрхийлэх /Биеийн хэлэмжийг зөв зохистой ашиглах, ярианы болон бичгийн ур чадвараа сайжруулах/</p>
<p>5. <b>БАГААР АЖИЛЛАХ</b></p>	<p>5.1 Хамтын зорилгоо тодорхойлох 5.2 Хамтран төлөвлөх, хэрэгжүүлэх 5.3 Нөөцийг хуваарилах 5.4 Бусдын санал зөвлөмжийг хүлээн авах болон бусдад санал зөвлөгөө өгөх 5.5 Зөрчлийг бүтээлчээр зөвшилцөх</p>
<p>6. <b>ТУНГААН БОДОХ</b></p>	<p>6.1 Мэдээлэл цуглуулах 6.2 Учир шалтгаанд дүн шинжилгээ хийх 6.3 Дасан зохицох 6.4 Ёс зүйтэй шийдвэр гаргах /Зөв бурууг эргэцүүлэн, тогтвортой байдлыг эрхэмлэх/ 6.5 Эргэцүүлэн тунгаах</p>

**С. Мэдлэг:** Энтрепренершип үйл ажиллагаанд шаардагдах бизнес төлөвлөлт, нөөцийн хуваарилалт, санхүүгийн болон дижитал мэдлэг, ёс зүйн талаарх ойлголт багтана. Энэхүү мэдлэгийн хүрээнд суралцагчид дараах тодорхой мэдлэгийг хөгжүүлэх боломжтой.

 <p><b>Энтерпренер-шипийн суурь мэдлэг</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Энтерпренершипийн талаарх ойлголт, мэдлэг, нийгмийн болон бизнесийн энтерпренершип, тухайн орон нутаг дахь түгээмэл жишээ</li> <li>• Энтерпренерийн зайлшгүй эзэмшсэн байх ур чадвар, онцлог, орон нутаг дахь энтерпренерийн зарим жишээ</li> <li>• Энтерпренершипийн арга замууд, оролцогч талууд, орон нутаг дахь онцлог</li> <li>• Шинэлэг бизнесийн санаанууд, нийгмийн энтерпренершипийн боломжууд</li> </ul>
 <p><b>Бизнес төлөвлөлт</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Бизнес төлөвлөлт гэдэг нь ирээдүйд чиглэсэн зорилгыг тодорхойлох, энэ зорилгод хүрэхэд шаардагдах нөөцийг тодорхойлох, зохистой хуваарилахыг сурах</li> <li>• Төлөвлөлт хийхэд санхүү, хүний нөөц, үйл ажиллагаа, маркетинг гэх мэт бизнесийн олон янзын салбарын мэдлэг, чадвар шаарддаг болохыг ойлгох</li> <li>• Сургалтын дараа зорилтот сумын суралцагчид өөрсдийн гаргасан шийдэл, санааг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн буцалтгүй дэмжлэг олж авах төслийн бизнес төлөвлөгөөг боловсруулж, шалгаруулалтад оролцох боломжтой. Буцалтгүй дэмжлэгийг гарын авлагад бичсэнээр бизнес төлөвлөгөө нь хураангуй, зорилго ба хүрэх үр дүн, бүтээгдэхүүн, үйлчилгээний концепц, орц, нөөцийн (түүхий эд, материал) мэдээлэл, зах зээлийн шинжилгээ, маркетингийн стратеги, үйл ажиллагааны менежмент, засаглалын бүтэц, эрсдэлийн шинжилгээ, санхүүгийн төлөвлөгөө гэсэн бүтэцтэй байх юм.</li> </ul>
 <p><b>Санхүүгийн мэдлэг</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Энэ нь үндсэндээ санхүүгийн бичиг үсгийн чадвар буюу мөнгө, орлого, зарлага, өртөг зардал, төсөв, банк, зээл гэх мэт санхүүгийн суурь ойлголтууд байна. Санхүүгийн ухаалаг шийдвэр гаргах, зардал тооцох, төсөв хийх, зөв зарцуулах, хадгалах зуршилтай байхыг сургана. Түүнчлэн засгийн газрын тусгай сангууд, төрийн бус байгууллага, арилжааны банкны буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл гэх мэт санхүүгийн эх үүсвэрийн талаар мэдээлэл олж авах, ашиглахад сургана.</li> </ul>



**Нөөцийн  
зохистой  
хуваарилалт  
төлөвлөгөө  
боловсруулах,  
хэрэгжүүлэх**

- Төслийн санаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай материал, техник, дижитал нөөцийг тодорхойлох, хуваарилах, удирдах мэдлэг орно. Түүнчлэн бизнес эрхлэхэд хязгаарлагдмал нөөцийг хамгийн үр ашигтайгаар хэрхэн ашиглах, санхүү, мөнгөтэй холбоотой техникийн ур чадварт мөн сургана. Баг хамт олон бусад оролцогч талуудыг үр дүнтэй ажиллахад хэрхэн татан оролцуулах тухай ч мөн сургана. Бизнес эхлэх, хөгжүүлэх, өргөжүүлэхэд шаардлагатай худалдаа, арилжааны мэдлэг, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний дизайн гаргах, бизнес төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх талаарх ойлголт, мэдлэгтэй болох боломжийг олгоно.



**Дижитал  
мэдлэг**

- Энэ нь дижитал тоног төхөөрөмж, компьютер, программ, харилцааны аппликейшн ашиглах, цахим мэдээлэл авах, удирдах сүлжээний талаарх мэдлэг юм. Энэ сургалтын явцад дижитал хэлбэрийн агуулга судлах, харилцах, хамтран ажиллах, сурах, бизнесийн санаагаа хэрэгжүүлэх, нийгмийн үйл ажиллагаанд оролцох, асуудлаа үр дүнтэй шийдэхэд дижитал тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглахад сургана.

# 2. АГУУЛГА

## 2.1 Агуулгын тойм, суралцахуйн цикл

Сургалтын агуулга нь суралцагчдад эзэмшүүлэхийг зорьж буй мэдлэг, чадвар, сэтгэлгээгээр тодорхойлогдох бөгөөд эдгээрийг хөгжүүлэхэд чиглэсэн дараах сэдэвт үйл ажиллагаатай байна. Үүнд:

- 1 МИНИЙ ЭНТРЕПЕНЕРШИП ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАР
- 2 ЭНТРЕПЕНЕРШИПИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА
- 3 ЭНТРЕПЕНЕРШИП ХЭРЭГЦЭЭ, БОЛОМЖУУД
- 4 ЭНТРЕПРАЙС ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ
- 5 ЭНТРЕПРАЙС ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТАНДАЛТ
- 6 ЭНТРЕПРАЙС ТӨСЛИЙГ САЙЖРУУЛАХ
- 7 ШИНЭ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

Сургалт нь дээрх сэдвүүдийн дагуу зохион байгуулагдах ба экспансив суралцахуйн 7 циклт үйл ажиллагаатай байна. Төсөлд суурилсан сургалтын явцад суралцагч хүүхэд залуучууд бодит амьдралын орчноос бий болсон энтрепренершип төслийг тогтсон циклийн дагуу боловсруулах, турших, үр дүнг дүгнэх, сайжруулах боломжтой болно. Энд дээрх цикл бүхий төлөвлөлт их чухал.

Суралцагчид тодорхой төслийн асуудлыг өөрийн нүдээр харж асуудлыг ойлгох, боломжийг илрүүлэх, санаагаа төсөөлөх, зорилгоо тодорхойлох, зорьсон санаагаа амьдралд хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаа орно.

Түүнчлэн төсөл эсвэл загвар боловсруулах, түүний загвар дизайныг хийх үйл ажиллагаа багтана. Энэ нь зураг, график гэх мэт багаараа бүтээсэн тодорхой зүйл байх юм. Ялангуяа жишиг төсөл эсвэл загвартай байх нь их чухал. Учир нь энэ нь хүмүүст нүдээр харж, биеэр мэдрэх, туршиж үзэх боломжийг олгодог. Жишиг

төсөл эсвэл загвартай байвал энэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар хэрэглэгчдэд танилцуулж, тэдний санал бодлыг сонсох, түүний дагуу сайжруулах боломжийг олгоно.

Суралцагчдад багаараа хамтран төлөвлөсөн нөөц, санхүүжилтээ ашиглан тодорхой хугацаанд ажиллаж үр дүн, амжилтаа хэмжих, санаагаа бодитойгоор хэрэгжүүлэх боломж олдоно. Мөн тэд өөрсдийн таамаглал, шийдвэр, үйл хэргээ эргэн харж, дүгнэх болно. Юу амжилттай болсон, өөрөөр яаж хийх боломж байсан, бодит нөхцөл ямар байсан гэх мэт.

## 2.2 Сэдвүүд ба хувь хүний ур чадварын уялдаа

Сургалтын сэдэв болон дэд сэдвийг судлах явцад суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг дараах байдлаар тайлбарлалаа.

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	СУРАЛЦАГЧДЫН ЭЗЭМШИХ		
		МЭДЛЭГ	ЧАДВАР	СЭТГЭЛГЭЭ
СЭДЭВ 1	<b>1.1 Хувь хүний сэтгэл хөдлөл, өөртөө итгэх итгэл</b>	Нийгмийн сэтгэл зүйн мэдлэг	Өөрийн хүчинд итгэх, өөрийгөө таних, сэтгэл хөдлөлөө тодорхойлох, хариу үйлдлээ мэдэх	Сэтгэлгээний-хээ онцлог, хэв шинжийг таньж мэдэх
	<b>1.2 Хамтрагчийн хувь хүний онцлогийг таних</b>		Өөрийгөө бодитоор тодорхойлох, баг бүрдүүлэх, багаар ажиллах, багийн үүргээ тодорхойлох, харилцах	Санаачилгатай байх
	<b>1.3 Цагийн менежмент</b>		Цагийн менежмент болон стрессээ удирдах	



сэдэв 2	<b>2.1 Энтрепренершип гэж юу вэ?</b>	Энтрепренер-шипийн суурь мэдлэг	Энтрепренер-шипийн нийгэм, соёлын орчлыг танин мэдэх, Бүтээлч байдал, инновацийн ур чадвар, Багаар ажиллах, Харилцах	Энтрепренер-шип сэтгэлгээ Нээлттэй хамтран ажиллах
	<b>2.2 Энтрепренер-шипийн арга замууд</b>			
	<b>2.3 Энтрепренер-шипийн оролцогч талууд</b>			
сэдэв 3	<b>3.1 Тухайн орон нутгийн иргэд, бүлэг нөхөрлөлийн хэрэгцээг тодорхойлох</b>	Дижитал мэдлэг, энтрепренер-шипийн суурь мэдлэг	Бүтээлч байдал, инновацийн ур чадвар, багаар ажиллах, харилцах, тунгаан бодох	Сониуч, санаачилгатай байх, энтрепренер сэтгэлгээ
	<b>3.2 Ялгаатай хэрэгцээг таних</b>			
	<b>3.3 Хэрэгцээг хангаж буй туршлагыг илрүүлэх, өөрсдийн санааг хөгжүүлэх</b>			
сэдэв 4	<b>4.1 Энтрепренер-шип санааг хөгжүүлэх, түүнийг хэрэгжүүлэх арга зам, боломж, саад бэрхшээл</b>	Энтрепренер-шипийн суурь мэдлэг	Энтрепренер-шипийн нийгэм, соёлын орчлыг танин мэдэх, Бүтээлч байдал, инноваци, Тунгаан бодох, Багаар ажиллах, харилцах	Сониуч, санаачилгатай байх, тодорхойгүй нөхцөл байдалд хүчин чармайлт гаргах, шаргуу байдал
	<b>4.2 Санхүүгийн нөөц</b>	Санхүүгийн мэдлэг		
	<b>4.3 Бизнес төлөвлөлт</b>	Нөөцийг хуваарилах, ашиглах, хэрэгжилтийн төлөвлөгөөг боловсруулах, явуулах тухай мэдлэг		
	<b>4.4 Төслийг хэрэгжүүлэхэд тулгарах эрсдэл, түүнийг бууруулах арга зам</b>	Эрсдэлийг урьдчилан харах, түүнийг бууруулах талаарх мэдлэг		

СЭДЭВ 5	<b>5.1 Энтрепрайс төслийн хэрэгжилтийн зохион байгуулалт</b>	Нөөцийн зохистой хуваарилалт, ашиглалт болон төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухай мэдлэг, Энтрепренер-шипийн суурь мэдлэг, санхүүгийн мэдлэг, дижитал мэдлэг	Энтрепренер-шипийн нийгэм, соёлын орчлыг танин мэдэх, Тунгаан бодох, Багаар ажиллах, харилцах,	Сониуч, санаачилгатай байх, тодорхойгүй нөхцөл байдал, эрсдэл, алдаанаас суралцах, хүчин чармайлт, шаргуу байдал
	<b>5.2 Энтрепрайс төслийн явц, үр дүнгийн тандалт</b>			
	<b>5.3 Төслийг үнэлж дүгнэх</b>			
СЭДЭВ 6	<b>6.1 Төслийг сайжруулах</b>	Нөөцийн зохистой хуваарилалт, ашиглалт болон төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухай мэдлэг, бизнес төлөвлөлт, санхүүгийн мэдлэг, дижитал мэдлэг	Бүтээлч байдал, инноваци, Тунгаан бодох, Багаар ажиллах, харилцах,	Санаачилгатай байх, тодорхойгүй нөхцөл байдал, эрсдэл, алдаанаас суралцах, хүчин чармайлт, шаргуу байдал
СЭДЭВ 7	<b>7.1 Шинэ төсөл боловсруулахад бэлтгэх</b>	Дээрх мэдлэг, чадвар, сэтгэлгээг хэрэглэн багаараа болон бие дааж шинэ төсөл боловсруулах		

Суралцагчдын зорилтот мэдлэг, чадвар, сэтгэлгээг зөвхөн сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан хөгжүүлэхэд хангалттай бус учраас багийн зохион байгуулалт, багийн оролцоо, чиг үүргээр дамжуулан хөгжүүлэх хэрэгтэй.

Багууд **мини-энтрепрайс** компани хэлбэрийн зохион байгуулалттай байх ба багийн суралцагчид менежерийн тодорхой албан тушаалтай байна. Энэ нь суралцагчдад дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээ хөгжих боломж олгоно. Үүнд:

- ✓ **Албан тушаалын чиг үүрэг, компаний ажил, зохион байгуулалтын талаарх мэдлэг**
- ✓ **Өөрийн хүчинд итгэх, цагийн менежментийн чадвар**
- ✓ **Идэвхтэй сонсох, асуулт асуух, санаагаа тайлбарлах, бусдын санааг ойлгох, үгээр болон бичгээр санал бодлоо илэрхийлэх**
- ✓ **Багаар ажиллах, нэгдсэн зорилгоо хамтдаа тодорхойлох, төлөвлөх болон зохион байгуулах,**
- ✓ **Алдаанаасаа суралцах, санаачилгатай байх, тодорхойгүй нөхцөл байдлыг урьдчилан төлөвлөх, эргэцүүлэх,**

Сургалтын явцад суралцагчид дараах үйл ажиллагаанд оролцох, технологийг хэрэглэх болно. Үүнд:

- ✓ **Бие даасан ажил**
- ✓ **Хос хосоороо ажиллах**
- ✓ **Багаар ажиллах**
- ✓ **Кейсүүдийг цуглуулах, дүн шинжилгээ хийх**
- ✓ **Танхимаас гадуур суралцах**
- ✓ **Орон нутгийн аж ахуй, иргэдийн төлөөллийг сургалтад урилгаар оролцуулах**
- ✓ **Энтерпрайсын үйл ажиллагааг зохион байгуулах**
- ✓ **Илтгэл, танилцуулга хийх**
- ✓ **Мэдээлэл харилцааны технологи (МХТ) ашиглах**

## 2.3 Агуулгын дэлгэрэнгүй, хугацаа

Дээрх сэдвүүдийн хүрээнд судлах дэд сэдэв болон суралцагчдын хөгжүүлэх мэдлэг, чадвар, сэтгэлгээг дараах хүснэгтэд үзүүлээ.

СЭДЭВ	СЭДВИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ	ХУГАЦАА
<b>МИНИЙ ЭНТРЕПРЕНЕР УР ЧАДВАР</b>		
<b>1.1 Хувь хүний сэтгэл хөдлөл, өөртөө итгэх итгэл</b>	<ul style="list-style-type: none"> <li>Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөл, түүний илрэх шинжийг тодорхойлох, удирдах</li> <li>Би хэн бэ? - Өөрийн арга барил, чадвар, давуу сул талыг танин мэдэх, өөрийнхөө талаарх итгэл үнэмшлийг тодорхойлох, сэтгэлгээний онцлог, хэв шинжийг таньж мэдэх</li> <li>Стресс менежмент</li> </ul>	<b>Танхим 80 минут</b>
<b>Танхимын бус үйл ажиллагаа</b>	<b>Бие даасан сорил</b>	<b>80 минут</b>
<b>1.2 Хамтрагчийн хувь хүний онцлогийг таних</b>	<ul style="list-style-type: none"> <li>Хамтрагчаа таньж мэдэх, сонгох</li> <li>Энтрепренешип баг бүрдүүлэх</li> <li>Багийн нийлмэл ур чадвар тодорхойлох, дутагдалтай ур чадварын жагсаалт гаргах</li> <li>Багтаа өөрийн гэсэн лого, нэршил сонгох, бие биэндээ зорьсон зорилгодоо хамтдаа хүрэх амлалт бичгээр өгөх гэх мэт</li> <li>Багийн ажлын чиг үүрэг</li> </ul>	<b>Танхим 80 минут</b>
<b>Танхимын бус үйл ажиллагаа</b>	<b>Бие даасан сорил</b>	<b>Танхимын бус 80 минут</b>
<b>1.3 Цагийн менежмент</b>	<ul style="list-style-type: none"> <li>Цаг төлөвлөх, багийн үйл ажиллагааны төлөвлөлт хийх түүнд МХТ ашиглах</li> <li>Төлөвлөлт хийх алхмууд</li> </ul>	<b>Танхим 80 минут</b>
<b>Танхимын бус үйл ажиллагаа</b>	<b>Багийн төлөвлөлт</b>	<b>Танхимын бус 80 минут</b>

## ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

<p><b>2.1 Энтрепренер-шип гэж юу вэ?</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Энтрепренершипийн онцлог, шаардлагатай чадамж (шинэлэг, бүтээлч байх, эрсдэлийг хянах, удирдах, эерэг хандлага гэх мэт) – Өөрийн болон багийн сорилын үр дүнтэй харьцуулах</li> <li>• Бизнесийн, нийгмийн энтрепренершип</li> <li>• Тухайн орон нутгийн энтрепренершипийн жишээ, онцлог</li> <li>• Энтрепренер ур чадвар</li> </ul>	<p><b>Танхим 120 минут</b></p>
<p><b>Танхимын бус үйл ажиллагаа</b></p>	<p><b>Бие даасан сорил</b></p>	<p><b>Танхимын бус 80 минут</b></p>
<p><b>2.2 Энтрепренер-шипийн арга замууд</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Энтрепренершип кейсүүд танилцуулах</li> <li>• Тухайн кейсүүдийг хөгжүүлэх санаанууд</li> <li>• Бодит жишээн дээр дүгнэлт хийх дасгал</li> </ul>	<p><b>Танхим 80 минут</b></p>
<p><b>Танхимын бус үйл ажиллагаа</b></p>	<p><b>Постер гаргах</b></p>	<p><b>Танхимын бус 80 минут</b></p>
<p><b>2.3 Энтрепренер-шипийн оролцогч талууд</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээний оролцогч талуудыг тодорхойлох             <ul style="list-style-type: none"> <li>• үйлчлүүлэгчид ба хэрэглэгчид</li> <li>• ажилчид, ажил олгогчид</li> <li>• ханган нийлүүлэгчид</li> <li>• зээлдүүлэгч, хөрөнгө оруулагчид</li> <li>• өрсөлдөгчид</li> <li>• орон нутгийн бизнесийн байгууллага</li> <li>• орон нутгийн засаг захиргаа</li> <li>• төрийн байгууллагууд</li> <li>• төсөл хэрэгжүүлэгчид, төрийн бус байгууллагууд</li> <li>• судалгаа, хөгжүүлэлт, чадавхжуулах байгууллагууд</li> </ul> </li> <li>• Талуудын үйл ажиллагаа, оролцооны чиглэл, хамтын ажиллагааг тодорхойлох, хооронд нь сумаар холбож зурах</li> <li>• Тухайн орон нутаг дахь бизнесийн байгууллагуудын харилцагч талууд, хамтын ажиллагааны чиглэл</li> </ul>	<p><b>Танхим 40 минут</b></p>

ЭНТРЕПРЕНЕРШИП ХЭРЭГЦЭЭ, БОЛОМЖУУД		
<b>3.1 Тухайн орон нутаг, бүлэг нөхөрлөл, иргэдийн хэрэгцээг тодорхойлох</b>	<ul style="list-style-type: none"> <li>Тухайн орон нутгийн бүлэг нөхөрлөл, иргэдийн хэрэгцээг тодорхойлох</li> </ul>	<b>Танхимд 80 минут</b>
<b>Танхимын бус үйл ажиллагаа</b>	<b>Хэрэгцээ тандах</b>	<b>Танхимын бус 80 минут</b>
<b>3.2 Ялгаатай хэрэгцээг таних</b>	<ul style="list-style-type: none"> <li>Багуудын тодорхойлсон хэрэгцээний талаар ойлгох</li> <li>Эдгээр хэрэгцээтэй холбоотой кейсүүдийг танилцуулах, учир шалтгааныг таньж мэдэх</li> </ul>	<b>Танхимд 80 минут</b>
<b>Танхимын бус үйл ажиллагаа</b>	<b>Кейс төсөл</b>	<b>Танхимын бус 80 минут</b>
<b>3.3 Хэрэгцээг хангаж буй туршлагыг илрүүлэх, өөрийн санааг хөгжүүлэх</b>	<ul style="list-style-type: none"> <li>Хэрэгцээг хангах боломжуудыг илрүүлэх</li> <li>Хэрэгцээг эрэмбэлэх, эдгээр хэрэгцээг хэрхэн хангах, одоогийн туршлага</li> <li>Энтерпренершип санааг сонгох</li> </ul>	<b>Танхимд 120 минут</b>
ЭНТРЕПРАЙС ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ		
<b>4.1 Энтерпренешип санааг хөгжүүлэх, түүнийг хэрэгжүүлэх арга зам, боломж, саад бэрхшээл</b>	<ul style="list-style-type: none"> <li>Энтерпренешип санаа түүний бизнес загвар боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх арга зам, боломжууд</li> <li>Боломжийг хэрэгжүүлэхэд тохиолдож болох бэрхшээлийг тодорхойлох</li> <li>Бэрхшээлийг даван туулах арга замыг тодорхойлох</li> </ul>	<b>Танхимд 160 минут</b>
<b>Танхимын бус үйл ажиллагаа</b>	<b>Энтерпренешип төсөл</b>	<b>Танхимын бус 80 минут</b>
<b>4.2 Санхүүгийн нөөц</b>	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн зохицуулалт, мөнгө, орлого, зардал, хуримтлал, хөрөнгө оруулалт, эрсдэл, даатгал гэх мэт Жишиг төслийг туршиж хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийн хуваарилалтыг хийх (санхүүгийн, хүний гэх мэт)</li> </ul>	<b>Танхимд 120 минут</b>

<p><b>4.3 Бизнес төлөвлөлт</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Бизнесийн загвараа тодорхойлох /хэнд, юуг, яаж, яагаад хүргэх – үр дүн болон үнэ цэнэ - бэлэн загвар ашиглах/</li> <li>• Бизнес төлөвлөгөөний бүтцийн дагуу төлөвлөлт хийх</li> <li>• Төлөвлөлт хийхэд МХТ хэрэгсэл, аппликейшн, ухаалаг төхөөрөмж зэргийг ашиглах</li> </ul>	<p><b>Танхимд 160 минут</b></p>
<p><b>Танхимын бус үйл ажиллагаа</b></p>	<p><b>Төслийн бизнес төлөвлөгөө боловсруулах</b></p>	<p><b>Танхимын бус 80 минут</b></p>
<p><b>4.4 Төслийг хэрэгжүүлэхэд тулгарах эрсдэл, түүнийг бууруулах арга зам</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Төслийг туршихад тохиолдож болох эрсдлийг урьдчилан хэлэлцэх, төслийн эрсдэлийг бууруулах, даван туулах арга замаа тодорхойлох</li> <li>• Үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, түүнд үндэслэн багийн гишүүдийн үүргийн хуваарилалтыг ур чадвартай нь уялдуулан хийх</li> <li>• Төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах эсвэл зайлшгүй холбогдох талуудыг тодорхойлох</li> <li>• Төслийг орон нутгийн оролцогч талуудад танилцуулах</li> </ul>	<p><b>Танхимын 80 минут</b></p>
<p><b>ЭНТРЕПРАЙС ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТАНДАЛТ</b></p>		
<p><b>5.1 Энтрепрайс төслийн хэрэгжилтийн зохион байгуулалт</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Төслийг хэрэгжүүлэлтэд оролцогч талууд, тэдгээрийн үүрэг хариуцлага</li> <li>• Төслийн хүрээн дэх хамтын ажиллагааны боломжууд</li> <li>• Орон нутаг дахь шинэлэг, бүтээлч шийдлийн үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээлийн тандалт</li> <li>• Бэрхшээлийг даван гарах боломжийн эрэлхийлэл</li> <li>• Өөрийн дэвшүүлсэн төслийн санаан дээр дэмжлэг авах, хамтран мэдээлэлтэй болох</li> </ul>	<p><b>Танхимд 80 минут</b></p>

# ЭНТРЕПЕНЕРШИПД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ ҮР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Танхимын бус үйл ажиллагаа	Энтрепенешип төслийн хэрэгжилт, хүрэх үр дүн төсөл	Танхимын бус 80 минут
<b>5.2 Энтрепрайс төслийн явц, үр дүнгийн тандалт</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Орон нутагт үйлдвэрлэж буй аль нэг бүтээгдэхүүнийг сонгож, түүний талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн мэдээлэл авах, үр дүн, дүгнэлт гаргах</li> <li>• Бүтээгдэхүүн үйлчилгээний шинэ хувилбарыг санал болгох</li> <li>• Шинэ саналаа холбогдох талуудад танилцуулах, санал зөвлөмж авах</li> </ul>	<b>Танхимын 80 минут</b>
<b>5.3 Төслийг үнэлж дүгнэх</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн болон Төслийн санхүүгийн дэмжлэгийн шалгуурын талаар ойлголттой болох</li> <li>• Шалгуур үзүүлэлтийг ашиглан өөрийн төсөлд үнэлгээ хийх</li> </ul>	<b>Танхимын 120 минут</b>
<b>ЭНТРЕПРАЙС ТӨСЛИЙГ САЙЖРУУЛАХ</b>		
<b>6.1 Төслийг сайжруулах</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээний үр дүнд үндэслэн төслийг сайжруулах</li> <li>• Сургалтын дүгнэлтийг хамтран хийх, хүлээж байсан үр дүндээ хүрч чадсан эсэхээ хувь суралцагчид дүгнэх</li> </ul>	<b>Танхимд 80 минут</b>
<b>ШИНЭ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ</b>		
<b>7.1 Шинэ төсөл боловсруулахад бэлтгэх</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Өмнөх сэдвүүдийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэлгээг хэрэглэн шинэ төсөл боловсруулах</li> </ul>	<b>Танхимын 80 минут</b>
<b>Танхимын бус үйл ажиллагаа</b>	<b>Шинэ төсөл боловсруулах</b>	<b>Танхимын бус 120 минут</b>



# 3. ҮНЭЭЛГЭЭ

## 3.1 Үнэлгээний арга

Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтад суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэлгээг дараах байдлаар үнэлнэ.

Суралцагчийн зорилтот мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд сорил, ажиглалтын хуудас болон дараах үнэлгээний аргуудыг ашиглана.

### Сорил

Сургалтын эхэнд болон төгсгөлд суралцагчид өөрийгөө үнэлэх сорил ажиллана. Энэ нь суралцагч өөрийнхөө хувь хүний ур чадварыг үнэлж байгаа сорил учир ямар нэгэн үнэлгээ тавигдахгүй. Үүнийг багшийн болон суралцагчийн гарын авлагад тусгасан болно.

### Ажиглалт

Багш сургалтын явцад хоёр төрлийн ажиглалтын хуудас ашиглан суралцагчдын сэтгэлгээ, ур чадварын ахицыг тэмдэглэнэ. Энэхүү ажиглалт нь суралцагчдын сэтгэлгээ, ур чадварыг үнэлэх бус харин суралцагчийн тухайн сэтгэлгээ, ур чадварын хөгжил нь үйл ажиллагаагаар нь хэрхэн илэрч буйг тэмдэглэх, цаашид ямар сэтгэлгээ, ур чадварыг нь хөгжүүлэх шаардлагатай, түүнд багшийн зүгээс хэрэгтэй чиглүүлэг, дэмжлэгийг тодорхойлоход чухал үүрэгтэй.

### Үнэлгээ

Үнэлгээ нь суралцагчийн өөрийн үнэлгээ, найз нөхдийн үнэлгээ, багшийн үнэлгээнээс бүрдэнэ. Суралцагчийн өөрийн болон найз нөхдийн үнэлгээний хуудсыг гарын авлагын тодорхой сэдэв бүрийн дараа оруулсан байгаа бөгөөд хэрхэн яаж үнэлэхийг мөн тайлбарласан болно.

**А.** Өөрийн үнэлгээ гэдэг нь сэдэв 1, 3, 5 -ын төгсгөлд өгөгдсөн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу суралцагчид өөрийгөө үнэлж буйг хэлнэ. Өөрийн үнэлгээний дунджийг гаргахдаа үнэлгээ тус бүрийн хувийг тооцож тэдгээрийн нийлбэрийн дунджаар гаргана.

**В.** Найз нөхдийн үнэлгээ гэдэг нь сэдэв 2 ба 4-ийн төгсгөлд өгөгдсөн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу багийн аль нэг гишүүнээр хийлгэж буй

үнэлгээг хэлнэ. Найз нөхдийн үнэлгээний дунджийг гаргахдаа үнэлгээ тус бүрийн хувийг тооцож тэдгээрийн нийлбэрийн дунджаар гаргана.

Багшийн үнэлгээ нь тест ба төслийн үнэлгээнээс бүрдэнэ.

**С.** Тестийн үнэлгээ гэдэг нь сургалтын төгсгөлд суралцагчдаар ажиллуулсан тестийн дүн байна. Тестийн даалгаврууд тус бүр ялгаатай үнэлгээтэй бөгөөд нийт **25** оноотой.

**Д.** Төслийн үнэлгээ нь **10** шалгууртай. Шалгуур бүрийг багш **1-10** оноогоор үнэлж тэдгээрийн нийлбэрээр үр дүнг тооцно.

### А. Өөрийн үнэлгээг тооцох арга

Сэдэв 1	Сэдэв 3	Сэдэв 5	ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ
Авах ёстой оноо <b>72-100%</b>	Авах ёстой оноо <b>42-100%</b>	Авах ёстой оноо <b>66-100%</b>	(1.4 * X + 2.4 * X + 1.52 * X) : 3 = ...%
<b>1.4 * X =</b> Гүйцэтгэлийн хувь	<b>2.4 * X =</b> Гүйцэтгэлийн хувь	<b>1.52 * X =</b> Гүйцэтгэлийн хувь	

### В. Найз нөхдийн үнэлгээг тооцох арга

Сэдэв 2	Сэдэв 4	ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ
Авах ёстой оноо <b>30-100%</b>	Авах ёстой оноо <b>54-100%</b>	(3.34 * X + 1.85 * X) : 2 = ...%
<b>3.34 * X =</b> Гүйцэтгэлийн хувь	<b>1.85 * X =</b> Гүйцэтгэлийн хувь	

## Багшийн үнэлгээг тооцох арга

C. Тестийн дүн	D. Төслийн үнэлгээний дүн
Нийт авах ёстой оноо <b>25-100%</b>	Нийт авах ёстой оноо <b>100-100%</b>
$4 * X = \dots\%$	$1 * X = \dots\%$

## Сургалтын эцсийн үнэлгээ

Сургалтын эцсийн үнэлгээг сургалтын явцад хийсэн суралцагчийн өөрийн болон найз нөхдийн үнэлгээнүүдийн дундаж, сургалтын төгсгөлд хийх тестийн дүн, төсөлт ажилд өгсөн багшийн үнэлгээний дүнгийн нэгтгэлээр тооцно.

## Сургалтын эцсийн үнэлгээг тооцох арга

A Өөрийн үнэлгээ дундаж	B Найз нөхдийн үнэлгээ дундаж	C Тестийн дүн	D Төслийн дүн	Сургалтын эцсийн дүн
25%	25%	15%	35%	100%
$0.25 * X = \dots\%$	$0.25 * X = \dots\%$	$0.15 * X = \dots\%$	$0.35 * X = \dots\%$	$A * 0.25 + B * 0.25 + C * 0.15 + D * 0.35 = \dots\%$
Өөрийн үнэлгээний дунджийн 25%-д ноогдох хувь	Найз нөхдийн үнэлгээний дунджийн 25%-д ноогдох хувь	Тестийн 15%-д ноогдох хувь	Төсөлт ажлын 35%-д ноогдох хувь	
Сэдэв 1,3,5-ын төгсгөлд	Сэдэв 2,4-ийн төгсгөлд	Сэдэв 7-ын төгсгөлд	Сэдэв 6-гийн төгсгөлд	

## 3.2 Үнэлгээний зорилт

Дараах **МЭДЛЭГИЙГ** үнэлнэ. Үүнд:

- Энтрепренершип үйл ажиллагааг эрхлэхэд шаардагдах санхүүгийн мэдлэг
- Бизнес төлөвлөлт
- Дижитал мэдлэг
- Ёс зүйн талаарх ойлголт

Дараах **ЧАДВАРЫГ** үнэлнэ. Үүнд.


- Суралцагчдын өөрийгөө болон бусдыг танин мэдэх,
- Цагаа зөв хуваарилах, саад бэрхшээлээ таньж мэдсэний үндсэн дээр оновчтой төлөвлөх
- Энтерпрайс боломжийг нээн илрүүлэх
- Бүтээлч, шинэ санаа гаргаж, турших
- Янз бүрийн нөхцөлд, зохих арга техникийг ашиглан үр дүнтэй харилцах
- Багаар ажиллах
- Нийгэм, соёлын үзэгдэлд хүндэтгэлтэй хандах
- Тунгаан бодох- мэдээлэл цуглуулах, шалтгааныг дүгнэх
- Ёс зүйтэй шийдвэр гаргах, эргэцүүлэн бодох
- Дасан зохицох



# ЭНТРЕПРЕНЕРШИПД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Дараах **СЭТГЭЛГЭЭГ** үнэлнэ. Үүнд:

- Суралцагчдын ажил, даалгавар хэр их бэрхшээлтэй байгаагаас үл хамааран аливааг илүү сайн хийх хичээл зүтгэлтэй байх
- Алдаанаасаа суралцаж, зорилгодоо хүрэхийн тулд өөрийгөө сорих, шаргуу байх
- Бусдын туршлагыг сонирхож, аливаад нээлттэй сэтгэж, асууж, сонирхох, санааг үйл хэрэг болгох, хэцүү бэрхшээлтэй үед бусадтай хамтран даван туулах урам зориг, санаачилгатай байх, тодорхойгүй нөхцөл байдлыг зохицуулах, эрсдэлийг бууруулахад суралцах чанарууд



A large, stylized teal gear graphic is positioned on the left side of the page. It has a thick outline and a smaller, semi-transparent version of itself inside, creating a layered effect. The gear is centered vertically and partially overlaps the text.

# 4. Нэр томъёо

# ЭНТРЕПРЕНЕРШИПД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

## ENTERPRISE

Нийгэм, хүмүүнлэг болон экологийн чиглэлийн бизнесийн үйл ажиллагаа хэрэгжүүлдэг этгээд

Ихэвчлэн мөнгө олох зорилготой бизнесийн болон бусад хэлбэрийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээд (<https://dictionary.cambridge.org/dictionary/english/enterprise>)

## BUSINESS ENTERPRISE

Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл болон борлуулалттай холбоотой үйл ажиллагаа эрхлэн ашиг олдог этгээдийг хэлнэ. (<https://bizfluent.com/about-6721330-business-enterprise-.html>)

## SOCIAL ENTERPRISE

Зөвхөн ашиг олох зорилгоор бус, нийгмийн сайн сайхны төлөө явуулж буй нийгэм, хүмүүнлэг болон экологийн чиглэлийн үйл ажиллагаа. (Гарааны бизнес, түүнтэй холбогдох нэр томъёоны тайлбар толь, 2016)

## ENTREPRENEUR

Ажил олгогч, Бизнес эрхлэгч

Шинэ аж ахуй, бизнес, нийгмийн тустай үйл ажиллагаа эхлүүлэх болон зохион байгуулах санхүүгийн эрсдэлийг үүрч буй хүнийг хэлнэ. (Cambridge International AS and A Level Business Coursebook Third Edition. Peter Stimpson and Alastair Farquharson. Page 11)

## ENTREPRENEURSHIP

Бүтээлчээр сэтгэж, шинэ зүйл санаачлан, ашиг олох зорилгоор бизнес эрхлэх үйл ажиллагаа. (Гарааны бизнес, түүнтэй холбогдох нэр томъёоны тайлбар толь, 2016)

## MONEY

Мөнгө

Үнэ цэнээ хадгалдаг, төлбөрийн хэрэгсэл болон өртгийн хэмжүүрийн үүрэг гүйцэтгэдэг хэрэгсэл юм. (<https://www.merriam-webster.com/dictionary/money>)



## INCOME

Орлого

Бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авагчдад зарж борлуулснаас олох мөнгө. (Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь, Монголбанк, 2015)



## EXPENSE

Зардал

Ямар нэгэн зүйлийг олж авах, худалдан авахад төлж буй дүн. (Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь, Монголбанк, 2015)

## RISK

Эрсдэл

Мөнгөө алдах, алдагдал хүлээх магадлал, мөн тодорхой бус байдлыг хэлнэ. (Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь, Монголбанк, 2015)



## SAVING

Хадгаламж

Санхүүгийн дансанд хуримтлуулахаар байршуулсан мөнгөн хөрөнгө (Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь, Монголбанк, 2015)



## INSURANCE

Даатгал

Даатгалын компаниас эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насанд хохирол учирвал нөхөн төлбөр олгох баталгаа. Даатгалд хамрагдахын тулд зохих хураамжийг төлснөөр энэхүү баталгааг худалдан авна. (Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь, Монголбанк, 2015)



## MIND MAPPING

Оюуны зураглал

Энэ нь ямар нэг бүтэц эсвэл дарааллын тухай бодолгүйгээр өөрийн оюун бодлоо зохион байгуулах хялбар арга бөгөөд ямар нэг асуудалд дүн шинжилгээ хийх, сэргээн санахын тулд бодлоо зураглах боломжийг олгодог. Оюуны зураглалаар дамжуулан гол асуудалтай холбоотой санаа, ухагдахуун болон үзэл санааг шугаман бус график ашиглан илэрхийлж чаддаг.




**ЭНТРЕПРЕН**

**СУУРИЛСАН ХУВЬ ХҮ**

**ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛ**


**ЕРШИПД**  
**ҮНИЙ УР ЧАДВАРЫГ**  
**ТЫН ХӨТӨЛБӨР**




ОРОН НУТГИЙН ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ХУВЬ  
ХҮНИЙ УР ЧАДВАР, ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН  
БОЛОВСРОЛ ОЛГОХ ТӨСӨЛ

 Вебсайт: [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

 Facebook: Save the Children in Mongolia

 Twitter: Save the Children MN

 Утас: 11-329365